



ЗАМЫН-ҮҮД ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 31 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Үйлчилгээний хөлс, төлбөр, хураамжийн хэмжээг тогтоох тухай

Чөлөөт бүсийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6, 8.7.1, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 15 дугаар зүйлийн 15.1.1, 15.1.3, 15.1.4, 15.3.2, 15.3.6, 26 дугаар зүйлийн 26.1.2, 35 дугаар зүйлийн 35.1.5, 35.2.1, 35.2.2, 35.2.3, 39 дүгээр зүйлийн 39.1.5, 39.1.6 дахь хэсгийн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн ажлын албанаас үзүүлэх үйлчилгээний хөлс, төлбөр, хураамжийн хэмжээг хавсралт ёсоор баталсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гэрээ эрх зүй, хүний нөөцийн хэлтэс (Б.Ономаа)-т, Дэд бүтцийн хөгжил, газрын харилцааны хэлтэс (Ш.Амартүвшин)-т, Бүртгэл санхүүгийн хэлтэс (Д.Билгээ)-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж батлагдсантай холбогдуулан “Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн 2015 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А/72 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАХИРАГЧИЙН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ГАНБАТ

00230119

“Замын-Үүд” чөлөөт бүсийн Захирагчийн
2023 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн
тоот захирамжийн 1. дүгээр хавсралт

УХА0373
9129154 111510 0506

“ЗАМЫН-ҮҮД” ЧӨЛӨӨТ БҮСИЙН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНААС ҮЗҮҮЛЭХ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС, ТӨЛБӨР, ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Үйлчилгээний хөлс, төлбөр, хураамжийн төрөл	Үйлчилгээний хөлс, төлбөр, хураамжийн хэмжээ (төгрөгөөр)
1. Үйлчилгээний хөлс		
1.1.	Газрын дуудлага худалдаа, төсөл шалгаруулах баримт бичиг хүлээн авах үйлчилгээний хөлс	12,500 (арван хоёр мянга таван зуу)
1.2.	Лавлагаа гаргаж өгөх (Газар олголт, хуулийн этгээдийн бүртгэлтэй холбоотой болон бусад үйл ажиллагаатай холбоотой архивын материал)	5,000 (таван мянга)
2. Төлбөр		
2.1.	Чөлөөт бүсэд газар ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт, дуудлага худалдааны анхны үнэтэй тэнцэх хэмжээний нэг удаагийн төлбөр	Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 182 дугаар тогтоолоор тогтоосон Чөлөөт бүсийн 1 га газрын суурь үнэлгээ, Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 208 дугаар тушаалаар батлагдсан Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнэ тодорхойлох аргачлалыг тус тус үндэслэн бодсон нэг удаагийн төлбөр төлнө.
3. Хураамж		
3.1.	Чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийг бүртгэж, гэрчилгээ олгох	44,000 (дөчин дөрвөн мянга)
		Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийг бүртгэх – 750,000 (долоон зуун тавин мянга)
3.2.	Хуулийн этгээдийн өөрчлөлтийг бүртгэх	10,000 (арван мянга)
		Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн өөрчлөлтийг бүртгэх – 40,000 (дөчин мянга)
3.3.	Хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах	Гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн үйл ажиллагаа явуулах хугацааг сунгах – 75,000 (далан таван мянга)

3.4.	Газар ашиглах эрхийн гэрчилгээний хугацааг сунгах	12,000 (арван хоёр мянга)
3.5.	Чөлөөт бүсэд согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох	Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрөл олгох – 1,500,000 (нэг сая таван зуун мянга)
		11.00-22.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох – 1,000,000 (нэг сая)
		14.00-04.00 цаг хүртэл согтууруулах ундаагаар үйлчлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох – 3,000,000 (гурван сая)
		Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах – 500,000 (таван зуун мянга)
3.6.	Чөлөөт бүсэд экспортлох зорилгоор уламжлалт технологиор үйлдвэрлэх согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл	Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл олгох (хатуулгаас нь шалтгаалан)– 20,000,000 – 200,000,000 (хорин саяас хоёр зуун сая)
		Тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах – 10,000,000 – 100,000,000 (арван саяас зуун сая)
3.7.	Чөлөөт бүсэд тамхи худалдах үйл ажиллагаа эрхлэх энгийн зөвшөөрөл олгох	500,000 (таван зуун мянга)